

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.12.04

Орхон аймаг

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Салбарын хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, маркетингийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
1.1	Зорилт 1. Захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, байгууллагын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангана. /ТАТХ-ын 16, ЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”/	УТ 148.9	1.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт /хувь/ 2.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт /хувь/	1. 98 хувь 2. 96.5 хувь	1.100 хувь 2.100 хувь	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны “Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/18 дугаар тушаал, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2023 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/04 дугаар тушаалын дагуу 23 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хүнс, хөдөө аж ахуйн газар нь албаны зохион байгуулалтаар ажилладаг. Нийт 4 албатай. Захиргаа аж ахуйн алба 10, Мал үржлийн алба 3, Үйлдвэр, худалдаа үйлчилгээний алба 5, Хяналтын алба 5 албан хаагчтай. Төрийн захиргааны удирдах албан тушаалтан 1, төрийн захиргааны гүйцэтгэх 15, төрийн үйлчилгээний 7 албан хаагч ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон чадавхжуулах 2021-2024 оны сургалтын төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан. Албан хаагчдын ажиллах нөхцөл,	100%

						нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай, Байгууллагын сургалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелүүлж ажилласан.	
1.1.1	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд мэдээлэл оруулах. /ТАТХ-ын 16, ЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам/	-	1.Албан хаагчийн тоо 2.Мэдээллийн иж бүрэн байдал	1. ТЗ-16, ТҮ-7 нийт 23 2. 100 хувь	1. ТЗ-16, ТҮ-7 нийт 23 2. 100 хувь	Төрийн Захиргааны 16, Төрийн үйлчилгээний 7 албан хаагчийн мэдээллийг Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо цахим системд бүрэн оруулж, хүний нөөцийн мэдээллийн шинэчлэлтийг тухай бүрд хийсэн. Үүнд: - Засгийн газрын 2024 оны 128, 84, 82 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган төрийн албан хаагчдын ангилал, цалингийн суурь, нэмэгдэл зэрэгт өөрчлөлт оруулан системд иж бүрэн шинэчлэл хийж ажилласан. -Улсад болон төрд ажилласан хугацаа, ажилласан хугацааны түүх, албан хаагчийн хувийн мэдээлэл, Газрын даргын Б тушаалыг PDF өргөтгөлөөр /ажилд орсон гарсан тушаал/ болон цалингийн суурь мэдээлэл, ангилал, шатлал, зэрэг дэв, хоол, унааны нэмэгдэл зэрэг мэдээллийг шинэчилсэн. -Сургалтад хамрагдсан сертификат, шагнал, хувь хүний ур чадвар болон “Хур систем”-ийн мэдээллийг татаж оруулсан. -Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо цахим системийн Албан тушаалын тодорхойлолт хэсэгт нийт 21 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг PDF өргөтгөлөөр болон word-оор шивж хадгалсан. -Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо цахим системд албан хаагч тус бүрийн ажил мэргэжлийн кодыг бүрэн шинэчилсэн.	100%

1.1.2	Арга хэмжээ 2. Байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах. Сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөөнд албан хаагчдын ёс зүйн харилцаа хандлагын сургалтыг тусгах /Төрийн албаны тухай хуулийн 55.3 дугаар зүйл, ЗГХЭГ-ын ХЭГ/444/	-	100 хувь	96.6 хувь Ёс зүйн сургалт зохион байгуулах 2 удаа	Эхний хагас жилд: Сургалт зохион байгуулсан байна. Ёс зүйн сургалт 1 удаа зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө бүрэн хэрэгжүүлсэн байна.	Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдыг чадавхжуулах 2021-2024 оны сургалтын хөтөлбөрийг Газрын даргаар батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 оны сургалтын төлөвлөгөөнд хууль, эрх зүйн сургалт, чадавхжуулах сургалт, салбарын мэргэжилтнүүдийн гадагш чиглэсэн сургалт гэсэн 3 зорилгын хүрээнд 21 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны жилийн эцсийн 21 арга хэмжээний биелэлт 100 хувь хэрэгжсэн.	100%
1.1.3	Арга хэмжээ 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. /Төрийн албаны тухай хуулийн 55.3 дугаар зүйл, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 7/	УТ 148.9	Хэрэгжилтийн хувь	98 хувь	Эхний хагас жилд: нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлжүүлж ажилласан байна. Жилийн эцэст: нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлжүүлж	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг 5 зорилт, 16 арга хэмжээний хүрээнд төлөвлөн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100%

					лж ажилласан байна.		
1.1.4	Арга хэмжээ 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн хууль тогтоомжийн сургалт зохион байгуулах. /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн хууль /	-	Сургалтын тоо	2 удаагийн сургалт зохион байгуулсан	Жилийн эцэст: 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна	Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилт 9 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай, хэрэгжилтийг Хууль эрх зүйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. "Жендерийн ерөнхий ойлголт, ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх нь" сэдвээр Орхон аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтэн сургагч багш Ц.Уянга сургалт зохион байгуулсан. Нийт албан хаагчдын 81.8 хувь буюу 18 албан хаагч сургалтад хамрагдсан. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулах сургалт Жендерийн үндэсний хорооны Ажлын албанаас зохион байгуулж, байгууллагаас 2 албан хаагч хамрагдсан. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулсан Жендерийн тэгш эрхийг хангах зорилгоор "Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад байгууллагаас 2 эмэгтэй 1 эрэгтэй албан хаагч хамрагдаж мэдээл авсан.	100%
1.1.5	Арга хэмжээ 5. Байгууллагын албан ажлын цаг ашиглалтыг сайжруулах	-	Албан хаагчид ажлын өдөр цахим бүртгэлийн системд	-	Ажлын цагыг бүрэн ашиглаж хэвшсэн байна.	Албан хаагчдын цагийн бүртгэлийг attendance management program цахим системээр бүртгэдэг бөгөөд сар болгон Ахлах нягтлан бодогч, Захиргаа аж ахуйн албаны дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад танилцуулан хянуулдаг. 2024 оны жилийн эцсийн байдлаар чөлөө авсан 22 удаа,	100%

			бүртгүүлсэн байдал			томилолтоор ажилласан 26 удаа, өвчтэй 5 албан хаагч, ээлжийн амралтын хоногоос хэсэгчлэн авсан 22 албан хаагч байна.	
1.2	Зорилт 2. Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулан, ил тод байдлыг хангана. /Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль 7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт/	УТ 389.1	1.Төсвийн зарцуулалт /сая.төг/ 2.Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө /сая.төг	1.Байгууллагын төсөв 643 сая.төг 2. Үндсэн хөрөнгө 271.2 сая төг, эргэлтийн хөрөнгө 281.1 сая төг	1.Байгууллагын төсөв 797 сая. төг 2.Үндсэн хөрөнгө 271.2 сая төг, эргэлтийн хөрөнгө 281.1 сая төг	2024 оны үндсэн үйл ажиллагааны зардалд 1,042.2 сая төгрөг батлагдсан. Эхний 11 сарын байдлаар 1,032.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд гүйцэтгэл нь 889.4 сая төгрөг, харилцагч байгууллага болон хувь хүмүүст үүссэн өглөг, авлага байхгүй. Байгууллагын санхүүгийн төсөв, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган байгууллагын ил тод байдлын салбар болон shilendans.gov.mn тухай бүрд нь мэдээллийг бүрэн оруулж байна.	100%
1.2.1	Арга хэмжээ 1. Байгууллагын төсөв, төлөвлөгөөг хийж батлуулах, батлагдсан төсвийн санхүүжилтийг хугацаанд нь авах, тайлагнах. /Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль 7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт/	УТ 389.1	1.Төсвийн зарцуулалт /сая.төг/ 2.Тайлагналт /хугацаа/	1.Байгууллагын төсөв 605 сая. Төг 2. 100 хувь	Жилийн эцэст: 1.Байгууллагын төсөв 797 сая. Төг 2. 100 хувь	2024 оны үндсэн үйл ажиллагааны зардалд 1,042.2 сая төгрөг батлагдсан. Эхний 11 сарын байдлаар 1,032.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд гүйцэтгэл нь 889.4 сая төгрөг, харилцагч байгууллага болон хувь хүмүүст үүссэн өглөг, авлага байхгүй. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ сар бүр гарган байгууллагын даргаар баталгаажуулан Санхүү төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж байна.	100%
1.2.2	Арга хэмжээ 2. Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн эзэмшил, хадгалалтын байдалд хяналт тавих, эд	-	1.Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө /сая.төг/	Үндсэн хөрөнгө 271.2 сая төг, эргэлтийн	Жилийн эцэст: Үндсэн хөрөнгө 271.2 сая төг, эргэлтийн	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон үндсэн хөрөнгийг тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн burtgel.pcsp.gov.mn цахим мэдээллийн санд 100 хувь мэдээлэн ажилласан. Албан хаагчдын эд хөрөнгийн	100%

	хөрөнгийн тооллого хийх. /Төсвийн тухай хууль 22, 24, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль/			хөрөнгө 281.1 сая төг	хөрөнгө 281.1 сая төг	бүртгэлийн картыг шинэчлэн байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хагас жилийн тооллогыг хийж гүйцэтгэсэн. Тооллогод байгууллагын үндсэн хөрөнгө, 22 албан хаагчийн эд хөрөнгө ашиглалтыг бүртгэн тоолсон. Илэрсэн зөрчилгүй, эд хөрөнгийн ашиглалт хэвийн байна. 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг Газрын даргын А/27 дугаар тушаалаар байгуулж 12 дугаар сарын 09-ний өдрөөс тооллого зохион байгуулна.	
1.3	Зорилт 3. Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангана. /Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 152 дугаар тогтоол 5 дугаар хавсралт/	-	Хэрэгжилт /хувь/	1.Тогтоол шийдвэр 96 хувь 2.ЗГҮАХ 88.3 хувь 3. ХХААГ-ын 2023 оны ГТ 96.5 хувь.	1.Тогтоол шийдвэр 100 хувь 2.ЗГҮАХ 95 хувь 3. ХХААГ-ын 2023 оны ГТ 100 хувь.	2024 онд дараах чиглэлээр хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажилласан. Үүнд: 1. Аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх Зөвлөмж ирүүлсний дагуу зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлд хяналт тавин 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр албан тоотоор хэрэгжилтийг хүргүүлсэн. 2. 2024 оны сүүлийн хагас жилд 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан бодлогын баримт бичгийн биелэлтэд шинжилгээ хийж, анхаарах асуудлаар 8 зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан. 3. ХХААХҮСайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн биелэлтэд шинжилгээ хийж, анхаарах асуудлыг тэмдэглэн албан хаагчдад хүргүүлсэн. Биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.	100%

						4. Газрын даргын А болон Б тушаалд дотоод хяналт хийж 5 зөвлөмж өгч, хяналт тавин ажиллаж байна. 5.Засаг даргын захирамжийн тайлан, санхүүгийн баримтад дотоод хяналт хийж 9 зөвлөмж хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. 6. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох үйл явцад дотоод хяналт хэрэгжүүлж, 6 зөвлөмж хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. 7. Байгууллагын даргын удирдамжаар Шинэ хөдөө төслийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хадгалалт, бүртгэл хөтлөлт зэрэгт дотоод хяналт хийж 4 санал дэвшүүлж, Баян-Өндөр сумын ЗДТГ-т 4, Жаргалант сумын ЗДТГ-т 1, Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт 4, санхүүгийн ажилтнуудад 2 зөвлөмж тус тус хүргүүлсэн. 8. Байгууллагын даргын удирдамжаар Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд дотоод хяналт хийж 1 санал, холбогдох мэргэжилтэнд 3, албан хаагчдад 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хүргүүлж ажилласан. 2025 онд дотоод хяналтын чиглэлээр ажиллах төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулж, ХХААЯ-нд 2024.12.01-ний дотор хүргүүлсэн. 2024.12.10-ны дотор 2024 оны дотоод хяналтын ажлын тайланг хүргүүлэхээр ажиллаж байна.	
1.3.1	Арга хэмжээ 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайланг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр	-	1.Хэрэгжилт /хувь/	ХХААГ-ын 2023 оны ГТ 96.5 хувь.	Эхний хагас жилд: ХХААГ-ын 2024 оны ГТ хэрэгжилтийг	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны жилийн эцсийн байдлаар 7 стратеги зорилгыг хэрэгжүүлэх 17 зорилт, 60 арга хэмжээг 99.7 хувьтай биелэгдсэн тайланг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол,	100%

	дүнг тооцох ажлыг зохион байгуулах. /Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 152 дугаар тогтоол 5 дугаар хавсралт/				хангаж ажилласан байна. Жилийн эцэст: ХХААГ-ын 2024 оны ГТ хэрэгжилт 100 хувь.	аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжийн дагуу нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийж хугацаанд нь Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Е-офисс систем, https://plan.igovernment.mn/planorgan/ программд хэрэгжилтийг бүртгэсэн.	
1.3.2	Арга хэмжээ 2. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 152 дугаар тогтоол 5 дугаар хавсралт/	-	1.Хэрэгжилт /хувь/	1.Тогтоол шийдвэр 96 хувь 2.ЗГҮАХ 88.7 хувь	Эхний хагас жилд: Тогтоол шийдвэрт, ЗГҮАХ-т хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна. Жилийн эцэст: Тогтоол шийдвэрт, ЗГҮАХ-т хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна. 1.Тогтоол шийдвэр 100 хувь 2.ЗГҮАХ 95 хувь	Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй бодлогын баримт бичгийн биелэлтийг 2024 оны эхний болон жилийн эцсийн байдлаар нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тус тус хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, УИХ-ын тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, ЗГ-ын албан даалгаварын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд 43 шийдвэрийг 100% хэрэгжүүлж, үнэлэх боломжгүй 1 шийдвэр, хяналтаас хасуулах 8 шийдвэрийн саналыг ХШҮХ-т хүргүүлсэн. ЗДҮАХ-ийн биелэлт 20 заалтаар 99%, шалгуур үзүүлэлт 13 заалтаар 98.4%-тай хэрэгжсэн байна. Биелэлтийг е-оффис программд оруулсан. Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлтийг 9 заалтаар	100%

						нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 97.8 хувьтай, шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 11 заалтаар 90%-ийн дундаж биелэлттэй байна. Орхон аймаг, Эрдэнэт хотын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 20 заалт 97.4%, шалгуур үзүүлэлтийн биелэлт 9 заалтаар 92.7% -ийн гүйцэтгэлтэй байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд малын вакцинжуулалт 96.5%, 2024-2025 онд нөөцийн мах нийлүүлэх ажил 50%-тай хэрэгжиж, нийт дундаж биелэлтийн хувь 98.1 байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 9 заалтыг 100% хэрэгжүүлсэн байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах тухай Засаг даргын 288-р захирамжийн хэрэгжилтийг 3 заалтаар 100% биелүүлснийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/03 дугаар тогтоол, Баян-Өндөр сумын Засаг даргатай байгуулсан Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.	
1.3.3	Арга хэмжээ 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд урьдчилсан	-	Хэрэгжилт /хувь/	96.5	Эхний хагас жилд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 8 чиглэлийн 38 заалтын биелэлт гарган 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 97.3 хувийн хэрэгжилттэй байна. Тайланг	100%

	хяналт шинжилгээ, үнэлгээ хийх / Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт, ЗГҮАХ, ЗДҮАХ/				Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Жилийн эцэст: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. 100 хувь	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Судалгаа, хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн.	
1.3.4	Арга хэмжээ 4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийн биелэлтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Биелэлт /хувь/	94 хувь	Эхний хагас жилд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол	Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5 тогтоол шийдвэр хяналтад байгаагийн 1 тогтоолыг хяналтаас хасуулах санал өгч, нийт 5 тогтоолын биелэлт гарган 2024 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст	100%

	/ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт, ИТХ-ын тогтоол, ЗДҮАХ/				шийдвэрийн биелэлтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна Жилийн эцэст: 100 хувь	хугацаанд нь хүргүүлсэн. И-офисс системд бүрэн оруулсан бөгөөд шийдвэрийн дундаж хэрэгжилт 96.7 хувьтай байна. Үүнд: "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 91.7% "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн биелэлт 92%-тай байна. Бусад тогтоол шийдвэр 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	
1.4	Зорилт 4. Байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхижүүлэн, төрийн байгууллагын цахим мэдээллийн системийн гүйцэтгэлийг хангана. /Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 3.9.3.9, 3.9.3.26 дахь заалт/	-	1.И-оффис системийн ашиглалт /хувь/ 2.Цахимжуулсан мэдээллийн тоо 3.Ил тод байдал /хувь/	1. 90 хувь 2. ХХААГ-ын даргын - А тушаал 37, Б тушаал 24, нийт 61 тушаал буюу 100 хувь 3. Шилэн дансанд нийт 126 мэдээлэл буюу 97.6 хувь	1. 100 хувь 2. 100 хувь 3. 100 хувь	1. 2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагад нийт 677 албан бичиг ирснийг цахимжуулсан бөгөөд шууд албан бичиг 370, хугацаатай албан бичиг 297 байна. Хүнс хөдөө аж ахуйн газраас төрийн байгууллага болон албан тушаалтад хандан нийт 361 албан бичиг явуулснаас 344 нь шууд албан бичиг, 17 хариу хүссэн албан бичиг байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтад гаргасан 203 өргөдөл, хүсэлт, гомдлыг бүртгэн хүлээн авч и-офисс цахим системд оруулан цахимжуулсан. Байгууллагын нийт албан хаагчид И-офисс системийн ашиглалтыг сайжруулан бусад төрийн байгууллагатай харилцан, уялдаа холбоог ханган ажиллаж байна. 2. Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын цаасан суурьтай газрын даргын - А тушаал 26 -Б тушаал 45, нийт 71 тушаалыг цахимжуулсан байна. Шил ажиллагаа https://shilen.gov.mn/ сайтад 5 бүлгийн 43 мэдээллийг https://hhaag.erdenet.mn/ ,	99.5%

						erdenet.mn сайтад нийтэд ил тод мэдээлж ажилласан талаар хугацаанд нь тайлагнасан. 3. Ерөнхий сайдын 2023 оны 01 албан даалгавар, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Орхон аймаг. Хүнс хөдөө аж ахуйн газар фэйж хаяг, Эрдэнэтэд үйлдвэрлэв фэйсбүүк хаяг, https://hhaag.erdenet.mn/ сайт, орон нутгийн телевизүүдээр Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн мэдээлэл, сургалт, зохион байгуулсан ажлын тайланг нийтэд ил тод мэдээлж, сурталчлан ажиллаж байна. Санхүүгийн болон хүний нөөцийн ил тод байдлыг ханган холбогдох мэдээллийг https://gap.mof.gov.mn/ системд тухай бүрт мэдээлж ажилласан. Албан хаагч солигдсонтой холбоотой, админ эрх шилжээгүй шалтгаанаар 2 дугаар сард 2 мэдээлэл, 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй мэдээлэл ороогүй 1-5 сар, хавсралт файл 4, 5 сарын мэдээ тус 3 мэдээ хугацаа хоцорч 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна.	
1.4.1	Арга хэмжээ 1. Аймгийн төрийн захиргааны байгууллагын нэгдсэн сүлжээ И-оффис системээр дамжуулан байгууллагын албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, мэдээллэх. /Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 3.9.3.9, 3.9.3.26 дахь заалт/	-	И-оффис системийн ашиглалт /хувь/	95 хувь	Эхний хагас жилд: И-оффис системийг үйл ажиллагаанд аа ашигласан байна. Жилийн эцэст: И-оффис системийн ашиглалт 100 хувь	И-оффис системийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд тайлан, дүн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай илгээх, хүлээж авах, солилцох, ирсэн баримт бичгийг цахимжуулах, бүртгэх шийдвэрлэлтэд хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн шатанд хадгалах, ашиглах зэрэг цогц үйл ажиллагаагаар байгууллагын цахим мэдээллийн гүйцэтгэлийг ханган ажилласан. Системын “Баримт бичиг төлөвлөх систем” талбарт гадагшаа явуулах бичиг, Газрын даргын тушаалууд шилжүүлж ажилласнаар тайлант хугацаанд “Бичиг	100%

						төлөвлөлт хяналт” талбарт 303 албан бичиг идэвхтэй бүртгэгдсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилтийг системийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” талбарт нийт албан хаагчид оруулж хэвшсэн.	
1.4.2	Арга хэмжээ 2. Байгууллагын цаасаар хадгалагдаж байгаа мэдээллийг цахимжуулах. /Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 3.9.3.9, 3.9.3.26 дахь заалт/	-	Цахимжуулсан мэдээллийн тоо	ХХААГ-ын даргын - А тушаал 48, Б тушаал 51, нийт 99 тушаал буюу 100 хувь	Эхний хагас жилд: ХХААГ-ын даргын тушаалыг цахимжуулсан байна. Жилийн эцэст: ХХААГ-ын даргын тушаалыг 100 хувь цахимжуулсан байна.	Жилийн эцсийн байдлаар байгууллагын цаасан суурьтай даргын А тушаал 26, Б тушаал 45, нийт 71 тушаалыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Байгууллагын Архивд хүлээн авсан хадгаламжийн нэгжүүдийг И-Оффис системийн архивын программд байнга хадгалах хадгаламжийн нэгж, түр хадгалах хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж гэсэн 3 данс болгон бүртгэлд оруулсан бөгөөд байнга хадгалах хадгаламжийн нэгж 41, түр хадгалах хадгаламжийн 50, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 4, нийт 95 хадгаламжийн нэгжийг цахимжуулсан.	100%
1.4.3	Арга хэмжээ 3. Шилэн данс shilendans.gov.mn-д мэдээлэл байршуулах. /Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,	-	Хэрэгжилт /хувь/	Шилэн дансанд нийт 129 мэдээлэл буюу 90 хувь	Эхний хагас жилд: Шилэн дансны мэдээллийг сайтад тухай бүр байршуулсан байна. Жилийн эцэст: Шилэн дансны мэдээллийг	Хүнс хөдөө аж ахуйн газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын ил тод байдлын мэдээллийг https://gap.mof.gov.mn/ системд мэдээлэл оруулах хэрэглэгчээр Захиргаа, аж ахуйн албаны дарга, хүний нөөц, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөө, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Ж.Баярмандах, Ахлах нягтлан бодогч О.Оюун-Эрдэнэ нар гүйцэтгэж байна. https://gap.mof.gov.mn/ системд санхүүгийн ил тод байдлыг ханган Шилэн дансны мэдээлэлийг цаг тухайд нь мэдээлж ажилласан. Ахлах нягтлан бодогч 2024 онд	98.1%

	нийтлэг стандартыг тогтоох журам”/				сайтад 100 хувь байршуулсан байна.	байгууллагын төсөв, санхүү тайлан мэдээ, худалдан авах ажиллагаа, аудиттай холбоотой нийт 159 мэдээлэл орууллахаас 156 мэдээллийг хуулийн хугацаанд 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	
1.4.4	Арга хэмжээ 4. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах. /Авилгын эсрэг хууль, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт/	-	Сургалтын тоо	1 удаагийн сургалтад 20 албан хаагч	Эхний хагас жилд: 1 удаагийн сургалтад 20 албан хаагчийг хамруулна. Жилийн эцэст: 1 удаагийн сургалтад 20 албан хаагчийг хамруулна.	2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах болон байгууллагын нийт албан хаагчдад авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, нийт албан хаагчдын 90.4 хувь буюу үйлчлэгч, жолоочоос бусад 19 албан хаагчийг хамруулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад өөрчлөлт орохтой холбогдуулан зохион байгуулсан цахим сургалтад нийт 18 албан хаагч хамрагдсан. Сургалтын үр дүнд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах арга зүйд суралцан 2024 онд нийт албан хаагчид ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан.	100%
1.5	Зорилт 5. Хүрээлэн байгаа орчны чанарыг дээшлүүлнэ. /Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2.3.3, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн /	-	1.Тарьсан модны тоо 2.Зөв дадал	-	1. 50 мод 2. Зөв дадал	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Тарлан толгойн төгөл уулын энгэрт хавар, намрын тарилтаар 60 ширхэг голт бор, буйлс, чацаргана, агч гэсэн 4 нэр төрлийн мод тарьж, усалгаа арчилгааг хийсэн. Байгууллагын албан хаагчдад хогийг ангилан ялгаж, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%
1.5.1	Арга хэмжээ 1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарьж, ногоон	-	Тарьсан модны тоо	Тарьсан модны тоо	Жилийн эцэст: 60 мод тарьсан байна.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Тарлан толгойн төгөл уулын энгэрт хаврын тарилтаар 18 ширхэг Буйлс модыг тарьж, усалгаа, арчилгаа хийсэн. 18 ширхэг Буйлс модыг 90,000 төгрөгөөр “Мэргэжил сургалт	100%

	байгууламжийг нэмэгдүүлэх. /“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн/					үйлдвэрлэлийн төвийн ойжуулах” ангиас худалдан авсан. Намрын мод тарилтаар албан хаагчид 160,000 төгрөгөөр Голт бор мод 20 ширхэг, чацаргана 20, агч 2 ширхэгийг тус тус тарьсан. Terbummod.mn сайтад байгууллагын тарьсан модыг бүртгэлжүүлсэн. Нийт 60 мод тарьсан байна.	
1.5.2	Арга хэмжээ 2. Олон талын оролцоог хангасан хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрт нэгдэх. /Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2.3.3/	-	Зөв дадал	Хог хаягдлын ангилан ялгаж, орчны бохирдлоо с урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	Жилийн эцэст: Зөв дадал төлөвшүүлнэ. /хог хаягдлыг ангилан ялгах/	Нийт албан хаагчид 6 удаа байгууллагын гадна хуваарьт талбайн цас, мөсийг цэвэрлэсэн. Байгууллагын ойролцоох гуу жалга, талбайн эргэн тойрны өнжмөл хогийг Их хотын цэвэрлэгээ аяны хүрээнд цэвэрлэж, Захиргааны 3 дугаар байрны 3 давхарт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх хуваарийг гарган, байрны их цэвэрлэгээг сар бүрийн 15-ны өдөр хийж хэвшсэн. Байгууллагын албан хаагчид хогийг ангилан ялгаж, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, үржил, селекц, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийг тухай бүрд баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
2.1	Зорилт 1. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	УТ 8.5 Шинэ хорошоо хөдөлгөөн 4,937.2 ХХСан 100.0	1.Сургалтад хамрагдсан хүний тоо 2.Дэмжлэгийн мөнгөн дүн /төгрөг/	-	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг сургалтанд хамруулж, чадавхжуулан мэдээллээр хангаж, дэмжлэг	1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 90 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн, өсгөн үржүүлэх болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн	100%

	/ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4/, /ЗДҮАХ-ийн 7.3.3, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ЖДҮХС 697.5			үзүүлсэн байна.	түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийг эзэмшсэн. 2. Хүнсний хангамж аюулгүйн байдлын хүрээнд 8.5 сая төгрөгийн үнэтэй хүнсний зориулалтын савыг сүүний 2 үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчдад олгон дэмжлэг үзүүлсэн. Мөн 4 аж ахуйн нэгж Хоршоо хөгжүүлэх сан, ЖДҮ дэмжих сангаас нийт 797.5 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. 3. Монгол Улсын Засгийн газраас санаачилсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд мал аж ахуйн чиглэлийн 30 хоршооны гишүүн 103 малчин 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан. 4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас Мал аж ахуйн чиглэлээр “Арга билиг арвин сүрэг” хоршоо 100 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая төгрөг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая төгрөг, Сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Рояал Алтай Констракшн ХХК 300.0 сая төгрөг, нийт 4 ААН 797.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	
2.1.1	Арга хэмжээ 1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах. /7.3.3/	-	Чадавхижуул ах сургалтад хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо	-	Жилийн эцэст: 2-оос доошгүй сургалтад хамруулж туршлага судалсан байна	1. Шинэ зууны мал аж ахуйн хөгжлийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх залуу малчдыг чадавхжуулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны хашаалсан бэлчээрт малыг тэжээх, эдийн засгийн тооцооллыг оновчтой хийх, техник тоног төхөөрөмжийг ашиглан хөдөлмөр хөнгөвчлөх, түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээлд нийлүүлэх, өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн өсгөн үржүүлэх болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй танилцан, туршлага судлах сургалтад Жаргалант сумын 1 залуу малчныг хамруулсан.	100%

						2. Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийн сургалтыг зохион байгуулж Баян-Өндөр, Жаргалант сумдын эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон эрхлэх сонирхолтой 65 малчин хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/480 дугаар захирамжийн хүрээнд Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах, сургалтад 20 малчинг хамруулсан. Төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэхэд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцлагатай мал үржүүлэг технологийн хэлэлцүүлэг болон “ШИЛМЭЛ МАЛ-2024” үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож туршлага судалсан.	
2.1.2	Арга хэмжээ 2. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих. /ЗДҮАХ, Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих үндэсний хөтөлбөр, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	УТ 8.5 ХХСан 100.0 ЖДҮХС 697.5	Дэмжлэгийн тоо /мөнгөн дүн/	Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлийн 5 аж ахуйн нэгж, 1 иргэн 3,800,000,0 төгрөгийг олгогдсон. “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 6 иргэнд 138.0 сая төгрөгийн	Жилийн эцэст: Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 1-2 иргэнийг дэмжлэгт хамруулсан байна.	2024 оны эхэнд аймгийн хэмжээнд 141 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаас 21 иргэн мах-сүүний чиглэлийн 369 толгой үхэр, 18 иргэн махны чиглэлийн 954 толгой үхэр, 2 иргэн 261 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 25 иргэн 2189 толгой ноолуурын чиглэлийн ямаа, 5 иргэн 134 толгой гахай, 56 иргэн 1090 толгой шувуу, 12 иргэн 237 бүл зөгий, 2 иргэн 15 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж байна. “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд “хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Чиглэл” ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын 40 литрийн бидон 16 ширхэг, айраг, сүүний сав 100 литрийн багтаамжтай 4 ширхэг савыг орон нутгийн сүү боловсруулах Баяжуулагч одод	100%

				хөнгөлөлттэй зээлийг олгосон.		ХХК, Эрдэнэт хаан сүү ХХК болон сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд олгож, дэмжлэг үзүүлсэн. Эрүүл ахуйн шаардлага хангасан сүүг малчдаас хүлээн авч сүүний үйлдвэрт нийлүүлснээр ард иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангах боломж бүрдсэн. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас Мал аж ахуйн чиглэлээр “Арга билиг арвин сүрэг” хоршоо 100 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая төгрөг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая төгрөг, Сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Роял Алтай Констракшн ХХК 300.0 сая төгрөг, нийт 4 ААН 797.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	
2.1.3	Арга хэмжээ 3. Мал сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулснаар өндөр ашиг шимт мал, амьтны тоо толгой өсөж, нийт сүрэгт эзлэх хувийн жин өсөх / Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.1.1/	-	Нийт мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоо, хувийн жин	2023 онд 175.3 мянган толгой мал тоологдсон. Нийт мал сүргийн 34.0 мянга толгой буюу 19.3 хувь нь өндөр ашиг шимт мал эзэлж байна	Жилийн эцэст: Өндөр ашиг шимт малын тоо 34.0 мянган толгой буюу өмнөх оноос 1-1.5 хувиар өссөн байна.	Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга, Дархад омгийн хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. Урьдчилсан байдлаар 2024-2025 онд 176.1 мянган толгой мал өвөлжиж, хаваржихаас нийт мал сүргийн 34.3 толгой буюу 19.5 хувийг цөм сүргийн мал эзэлж байна.	100%
2.2	Зорилт 2. Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна.	ОНТ 7.2	Үзлэг ангилалтанд хамрагдсан малын тоо /хувь/	2023 онд 37.5 мянган толгой мал үзлэг ангилалтанд хамруулж,	Малын чанар сайжирна. Бог малын нийт хээлтүүлэгч малыг 100 хувь үзлэг	1.2024 онд аймгийн хэмжээнд 40.0 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулан ажилласан. Хавар, намрын үзлэг ангилалтад бог малын 742 толгой хээлтүүлэгч 39.2 мянган толгой хээлтэгчийг 100 хувь хамруулан анги, чанарыг тодорхойлон ажилласан.	100%

	/Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.8.4, ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.5, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/			2000 толгой малд ялган тэмдэглэгээ хийж бүртгэлжүүлсэн	ангилалтанд хамруулсан байна. Бог малын өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан байна.	Мөн 1870 толгой үхрийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн малын үнэдсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Программд бүртгэгдсэнээр e-mongolia системээс малчин, мал бүхий этгээдийн тодорхойлолт авч, дэмжлэгт хамрагдах боломж бүрдсэн. 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2024 оны А/137 дугаар тушаалын хүрээнд Монгол үүлдрийн хуц-40 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан	
2.2.1	Арга хэмжээ 1. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх. Бог малын өсвөр хээлтүүлэгчийг нөхөн тавих. /Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.8.4, ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.5/	-	Богийн хээлтүүлэгч 848 толгой тоологдсоноос 85 хувь буюу 724 толгойг 4 суурьт ялган төвлөрүүлсэн.	Ялган төвлөрүүлсэн бог малын хээлтүүлэгчийн тоо	Эхний хагас жилд: Бог малын хээлтүүлэгчийн 70-аас доошгүй хувийг ялган төвлөрүүлнэ. 10-аас доошгүй бог малын хээлтүүлэгчийг шинээр сонгон тавьсан байна. Жилийн эцэст: Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ. 10-аас доошгүй бог малын	1."Малын генетик нөөцийн тухай" хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: аймгийн хэмжээнд 2024 оны эхэнд хуц-417, ухна-325 нийт-742 толгой хуц, ухна тоологдсоноос хаврын үзлэг ангилалтаар 603 толгой хуц, ухна буюу 81.2 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2. Монгол үүлдрийн хуц-40 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан.	100%

					хээлтүүлэгчийг шинээр сонгон тавьсан байна.		
2.2.2	Арга хэмжээ 2. Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах. /Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.8.6, ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.5/	ОНТ 7.2	1.Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн малын тоо 2.Ялган тэмдэглэгээ хийсэн малын тоо	37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийж, 2.0 мянган толгой малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулсан	Эхний хагас жил: 1. Аймгийн хэмжээнд нийт 27.3 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийх, 2. 1.5 мянган толгой үхрийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байна. Сүүлийн хагас жил: 1. Аймгийн хэмжээнд нийт 40.0 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан	1.Малын генетик нөөцийн тухай” хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2024 оны А/136 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/290 дугаар захирамжийн хүрээнд баталгаажсан үүлдэр омгийн мал сүрэгт хаврын үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийж, цөм сүрэг бүрдүүлэх, малын генетик нөөцийн төлөв байдал тодорхойлох ажлыг сумдын хөдөө аж ахуйн тасаг, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд 40.0 мянган толгой малыг хавар, намрын үзлэг ангилалтад хамруулахад бог малын 742 толгой хээлтүүлэгч, 39.2 мянган толгой хээлтэгчийг 100 хувь хамруулан анги, чанарыг тодорхойлон ажилласан. Үүнээс 7858 толгой буюу 19.6 хувь нь цөм сүрэг, 28652 толгой буюу 71.6 хувь нь үржлийн сүрэг, 3490 толгой буюу 8.7 хувь нь хэрэгцээний сүрэгт тус тус бүртгэгдсэн. 2. Мөн 1870 толгой үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.	100%

					баталгаажуул алт хийх, 2. Нийт 1.5 мянган үхрийг ялган тэмдэгдэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байна.		
2.3	Зорилт 3. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.4, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ОНХС 62.0	1.Бэлчээрийн усан хангамж /хувь/ 2.Тандалт судалгаа хийсэн талбайн хэмжээ /га/	1.Бэлчээри йн усан хангамж 82.8 хувьтай байна. 2. Нийт бэлчээрийн 10.0 хувь буюу 4.0 мян/га талбайд үлийн цагаан оготны тандалт судалгааг хийсэн	1.Малын бэлчээрийн усан хангамж 85 хувиас доошгүй байна. 2.Бэлчээрийн үлийн цагаан оготны тандалт судалгаа хийгдсэн байна.	1. Аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 87 худаг, уст цэг байгаагаас инженерийн хийцтэй худаг 81, усан сан 6 байна. Бэлчээрийн усан хангамж 87 хувьтай байна. 2. Манай аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай. Энэ жил бэлчээрийн талбайн 4000 га талбайд үлийн цагаан оготны тандалт судалгаа хийхэд бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгч, үлийн цагаан оготно илрээгүй.	100%
2.3.1	Арга хэмжээ 1. Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн	ОНХС 62.0	ОНХС Шинээр гаргасан, сэргээн	Бэлчээрт аймгийн хэмжээнд 5 худаг	Жилийн эцэст: 1 худаг шинээр	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 62.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 худаг шинээр гаргах ажлыг “ <u>Таширын хүрээ</u> ” ХХК	100%

	засварлаж малчдад эзэмшүүлэх. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.4/		засварласан худгийн тоо	шинээр гаргасан	гаргасан байна.	гүйцэтгэж улсын комисс хүлээн авч өмчид бүртгэгдсэн. Баян-Өндөр сумын Малчин багийн Цохионы өвөрт 1 худаг шинээр гаргаснаар 12 өрхийн 1500 толгой мал усаар хангагдсан.	
2.3.2	Арга хэмжээ 2. Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.4, ЗДҮАХ-ийн 7.3.4/	-	Тандалт судалгаа хийсэн талбайн хэмжээ /га/	Бэлчээрийн 39.3 га талбайтай. Нийт бэлчээрийн 10. хувь буюу 4.0 мян/га талбайд үлийн цагаан оготны тандалт судалгааг хийсэн.	Жилийн эцэст: Нийт бэлчээрийн талбайн 10 хувьд үлийн цагаан оготны тандалт, судалгааг хийсэн байна.	2024 онд нийт бэлчээрийн 10 хувь буюу 4000 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготны тандалт судалгаа хийхээс 2024 оны 05, 10 дугаар саруудад Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран бэлчээрийн 4000 га талбайд судалгаа хийж ажилласан. Тандалт судалгаанд Жаргалант сумын Дулаан-Уул багийн Баруун, Зүүн булаг, Зэрэглээ, Цагаан хуст, Тугалч, Панзын далиу зэрэг газруудыг хамруулахад бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгч, үлийн цагаан оготно илрээгүй.	100%
2.4	Зорилт 4. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.7, ЗДҮАХ-ийн 7.3.3 /	ОНТ 75.0 Баян- Өндөр 50.0 Жарга- лант 71.5	1.Өвс, тэжээл аюулгүйн нөөц бүрдүүлэлт /хувь/ 2.Тэжээл үйлдвэрлэлт /тн/	1.Өвс 200 тн, тэжээл 86.1 тн-ыг бэлтгэсэн. 2.Малчдын түвшинд байгалийн хадланг 100 хувь, тэжээлийг 100 хувь бэлтгэсэн.	Засгийн газрын тогтоолийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд мал аж ахуйн чиглэлээр 12, мал эмнэлгийн чиглэлээр 4, газар тариалангийн чиглэлээр 11, хүнсний чиглэлээр 1, нийт 28 заалт бүхий арга хэмжээг тусган, хэрэгжилтийг ханган ажилласан. ХХААХҮСайдын 2016 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг дүгнэж, аймгийн хэмжээнд 95.5 хувьтай хангасан мэдээг, төлөвлөсөн хугацаанд, ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн	100%

						бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.	
2.4.1	Арга хэмжээ 1. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.7, ЗДҮАХ-ийн 7.3.3/	ОНТ 75.0 Баян-Өндөр 50.0 Жаргалант 71.5	Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт /хувь/	Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1 тн бэлтгэсэн.	Жилийн эцэст: Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүлсэн байна.	2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр сум 50 сая төгрөг, Жаргалант сум 71.5 сая төгрөг нийт 196.5 сая төгрөгийг зарцуулж, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 25.0 тн тэжээл, Жаргалант сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 30 тн тэжээл, Баян-Өндөр суманд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 20 тн тэжээл, нийт 160 тн өвс, 75.0 тн тэжээлийг 100 хувь бэлтгэсэн.	100%
2.4.2	Арга хэмжээ 2. Малчдын түвшинд байгалийн хадлан бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.7, ЗДҮАХ-ийн 7.3.3, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	-	Бэлтгэсэн байгалийн хадлан, тэжээл /тн/	Малчдын түвшинд 9710 тн байгалийн хадлан, 390 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн.	Малчдын түвшинд 9500 тн-оос доошгүй байгалийн хадлан, 250 тн-оос доошгүй үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн байна	Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 11500 тн байгалийн хадлан бэлтгэхээс Баян-Өндөр сум -4000 тн, Жаргалант сум 7500 тн бэлтгэхээр төвлөсөн. Малчид өөрсдийн нөөц бололцоогоороо байгалийн хадлан 11722 тн, сүрэл 150 тн, үйлдвэрийн тэжээл 480 тн, ногоон тэжээл 1428 тн, гар тэжээл 107 тн, дарш, ногооны хаягдал 263.3 тн, хужир, шүү 310 тн-ыг тус тус бэлтгэж биелэлт 102.4 хувьтай хангасан.	100%
2.5	Зорилт 5. Малчдыг мэдээллээр хангаж, орон нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХ, ЗДҮАХ, Монгол малчин үндэсний хөтөлбөр/	ОНТ 5.0	Төрийн үйлчилгээ хүргэсэн малчин, мал бүхий иргэдийн тоо	-	Мал аж ахуйн талаар гарсан хууль тогтоомжийг сурталчилах, малчдыг мэдээллээр хангаж төрийн үйлчилгээг	“Малын генетик нөөцийн тухай” хууль, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг малчдад сурталчлан таниулах, хүн, мал эмнэлэг, төрийн үйлчилгээг үзүүлэх, мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт, цаг үеийн байдалтай танилцахаар жилд 4 удаа 10-12 чиглэлд ажлын хэсэг гарч Баян-Өндөр, Жаргалант сумдад давхардсан тоогоор 1263	100%

					хүргэсэн байна.	малчин өрхөд төрийн үйлчилгээг үзүүлэн ажилласан.	
2.5.1	Арга хэмжээ 1. Үржлийн стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчээр малчин мал бүхий иргэдийг хангах /Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйл/	-	Үржлийн шаардлага хангасан цөм сүргийн тоо	-	Эхний хагас жилд: Стандартын дагуу шаардлага хангасан хээлтүүлэгчийн судалгаа гаргах. Жилийн эцэст: Стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр малчин мал бүхий иргэдийг хангах.	2024 оны эхэнд аймгийн хэмжээнд нийт 1864 толгой хээлтүүлэгч тоологдсоноос 85.1 хувь буюу 1586 толгой нь үржлийн стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч байна. Үүнд: Буур-2, азарга- 663, бух- 247, хуц- 392, ухна- 282. Мах-ноосны чиглэлийн Барга үүлдрийн хуц, Эрчмийн хар үүлдрийн ухныг Баян-Өндөр, Жаргалант сумдын 39 малчин өрхөд 90 толгой хээлтүүлэгчийг түрээсээр ашиглах гэрээ байгуулан ажилласан. Бог малын чанарыг сайжруулсанаар малчин өрхийн махны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдсэн.	100%
2.5.2	Арга хэмжээ 2. Малчдад төрийн үйлчилгээг хүргэх. / Орхон аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол малчин үндэсний хөтөлбөр /	ОНТ 5.0	Төрийн үйлчилгээ хүргэсэн малчин мал бүхий иргэдийн тоо	2 сумын 9-12 чиглэлд 2 удаа давхардсан тоогоор 725 малчин өрхөд төрийн үйлчилгээг хүргэсэн	Төрийн үйлчилгээг малчин, мал бүхий иргэдэд хүргэсэн байна.	Аймгийн Засаг даргын А/42 дугаар захирамж, “Малын генетик нөөцийн тухай” хууль, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг малчдад сурталчлан таниулах, хүн, мал эмнэлэг, төрийн үйлчилгээг үзүүлэн мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын цаг үеийн байдалтай танилцах, “Малчдад тусалъя” аяны хүрээнд цугласан хандив, эрүүл мэндийн багцыг хүргэхээр Баян-Өндөр, Жаргалант сумдад 1, 2, 3, 9 дүгээр саруудад давхардсан тоогоор 1263 малчин өрхийн 1297 иргэнд хүн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хэмжээнд Мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрсэн тул аймгийн Засаг	100%

						даргын 2024 оны А/130, А/146 дугаар захирамжийн хүрээнд нэмэлтээр 2000 боодол өвс, 178.5 тн буюу 7142 шуудай тэжээл, 1670 ширхэг ашигт долооц, 600 кг биобэлдмэлийг 1179 малчин, мал бүхий өрхөд үнэгүй олгосон.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
3.1.	Зорилт 1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1, ЗДҮАХ-ийн 7.3.1, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	УТ 1,116.5 ОНТ 71.8 ЖДҮХС 100.0 Жаргалант 650.0	Тариалсан талбай, хураан авсан ургацын хэмжээ /га/тн/	Тариалсан талбай га: Үр тариа 4779 га, малын тэжээл 284 га, тосны ургамал 197 га, төмс 273 га, хүнсний ногоо 503 га, жимс жимсгэнэ 1.3 га буюу нийт 6037.3 га талбайд тариалалт хийсэн. Хураасан ургац тонн: Үр тариа 11530 тн, төмс 3072 тн, хүнсний ногоо 7317	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана.	Аймгийн хэмжээнд хаврын тариалалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2024 оны А/293, А/641 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Газар тариалангийн үйлдвэрлэлийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Жаргалант сумын Агро үйлчилгээний төв нь 124 иргэний 102.2 га талбайг хагалах, 2 иргэний 2.3 га талбайд бууц цацах, 66 иргэний 38 га талбайд төмс тарих, 22 иргэний 21 га талбайд хүнсний ногоо тарих, 47 иргэний 28 га талбайн хөрс бутлах, 3 иргэний 6 га талбайд ургамал хамгааллын бодис цацах, 6 иргэний 12 га талбайд ногоон тэжээл тариалах нийт давхардсан тоогоор 270 иргэний 209.5 га талбайд үйлчилгээ үзүүлсэн бол ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд иргэн, аж ахуйн нэгжийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүллээ. 2. Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрт Жаргалант сумын 500 өрхийг хамруулан үр олгож мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.	95.7%

				тн, тэжээлийн ургамал 1368 тн		3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/257 дугаар тушаалаар төмс, хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлж, Орхон аймагт 13.4 тн үр хуваарилсныг сумдын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж олгосон нь хэрэгцээт хүнсний ногооны үрийн 30 хувийг хөнгөлөлттэй нөхцөлөөр хангажээ. 4. Жаргалант сумын тариалангийн талбайг хашаажуулах ажлын хүрээнд: Бөөн бургас, 36-р точикт төмс, хүнсний ногооны талбайн 18.6 км хашааг шинээр барьж ашиглалтад оруулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тариалангийн талбайн хашааны төмөр бетон шон 24000 ширхэгийг манай аймагт хуваарилсныг татан авч 5153 га талбайг хашиж хамгаалсан. Энэ онд аймгийн хэмжээнд үр тариа 3841 га-д үүнээс 3723 га-д улаанбуудай, 118 га-д бусад үр тариа (вандуй, овьёос), 280 га-д малын тэжээл, 832 га-д тосны ургамал, 167 га-д төмс, 474 га-д хүнсний ногоо, нийт 5594 га-д тариалалт хийж, 3841 га-аас 10097 тонн үр тариа, 167 га-аас 1941 тонн төмс, 474 га-аас 12149 тонн хүнсний ногоо, 832 га-аас 284 тонн тосны ургамал, 280 га-аас 1294 тонн тэжээлийн ургамал тус тус хураан авсан. Энэ нь аймгийн хүн амын хэрэгцээт улаанбуудайг 100 хувь, төмсийг 51 хувь, хүнсний ногоог 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.	
3.1.1	Арга хэмжээ 1. Газар тариалангийн ажлыг технологийн зохистой хугацаанд хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.1, ЗДҮАХ-ийн 7.3.1, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ОНТ 1.8	Хангамжийн хувь	Улаанбуудай 100 хувь, төмс 43.3, хүнсний ногоо 100 хувь	Эхний хагас жилд: Технологит ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх. Жилийн эцэст:	Аймгийн хэмжээнд 393 иргэн 11 аж ахуйн нэгж газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үр тариа 3841 га-д үүнээс 3723 га-д улаанбуудай, 118 га-д бусад үр тариа (вандуй, овьёос), 280 га-д малын тэжээл, 832 га-д тосны ургамал, 167 га-д төмс, 474 га-д хүнсний ногоо, нийт 5594 га-д тариалалт хийж, 3841 га-аас 10097 тонн үр тариа, 167 га-аас 1941 тонн төмс, 474 га-аас 12149 тонн хүнсний ногоо 832 га-аас 284 тонн тосны ургамал, 280 га-аас 1294 тонн	100%

					Улаанбуудай 100 хувь, төмс 50 хувь, хүнсний ногоо 100 хувь	тэжээлийн ургамал тус тус хураан авсан. Энэ нь аймгийн хүн амын хэрэгцээт улаанбуудайг 100 хувь, төмсний 51 хувь, хүнсний ногоог 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.	
3.1.2	Арга хэмжээ 2. Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжилтийг хангах /ЗДҮАХ-ийн 7.3.2, Аймгийн ИТХ-ын 2021 оны 10 дугаар тогтоол/	ОНТ 70.0	Хамрагдсан өрхийн тоо	500	Эхний хагас жилд: 500	Орхон аймаг, Эрдэнэт хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусган, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор хөтөлбөрийг батлуулж, Засаг даргын 2024 оны А/72 дугаар захирамжаар 4 зорилт 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахаар орон нутгийн төсвөөс 70.0 сая төгрөг зарцуулж аймгийн, төмс, хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, сургалт арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан. Хөтөлбөрт Жаргалант сумын 500 өрхийг хамруулан 135 кг 4 төрлийн хүнсний ногооны үр, 30 тн төмсний үр олгон төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг багц сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 12 га талбайд төмс, 17 га талбайд лууван, 10 га талбайд шар манжин, 6 га талбайд хүрэн манжин, 4 га талбайд урт сонгино тариалж, 160 тн төмс, 974 тн хүнсний ногоо хураан авсан нь аймгийн хэмжээний нийт ургацын хэмжээтэй харьцуулахад төмсний 8 хувь, хүнсний ногооны 8 хувийг хураан авсан байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/257 дугаар тушаалаар төмс, хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлсөнтэй холбогдуулан Орхон аймагт 7.5 тн үрийн төмс, 5.9 тн 10 төрлийн хүнсний ногооны үр, нийт 13.4 тн үр хуваарилсныг сумдын Засаг даргын тамгын газартай хамтран тариаланчдад олгох ажлыг зохион байгуулсан. Нийт хүнсний ногооны үрийн хэрэгцээний 30 хувийг хөнгөлөлттэй	100%

						нөхцөлөөр олгож, 120 га талбайд хүнсний ногоо, 14 га талбайд төмс тариалсан. Жаргалант сумын хөтөлбөрт хамрагдсан өрхийн 46 хувь буюу 229 өрх нь газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх сургалтад хамрагдаж, plant.mofa.gov.mn цахим бүртгэлийн системд үйл ажиллагаагаа баталгаажуулсан. Орон нутгийн зах зээлд өөрийн үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоог нийлүүлж, 900.0 гаруй сая төгрөгийн урамшуулалд хамрагдах боломж бүрдүүлсэн.	
3.1.3	Арга хэмжээ 3. Тариалангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлэх /ЗГҮАХ 3.3.1. ЗДҮАХ-ийн 7.3.1, ОАХТЖҮЧ 8.5.2, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	-	Нэмэгдсэн тариалангийн талбайн хэмжээ /га/	45.19	Жилийн эцэст: 60	Тариалангийн талбайн газрыг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сум 2024 онд тариалангийн зориулалтаар 62.8 га талбай шинээр олгохоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. Баян-Өндөр сум хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 1.5 га, мод үржүүлгийн чиглэлээр 26 га газар иргэн, аж ахуйн нэгжид олгосон.	70%
3.1.4	Арга хэмжээ 4. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийж тариалалтад шаардлагатай улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэх /Тариалангийн тухай хууль 23.1/	-	Нөөцлөх үрийн хэмжээ /тн/	800	Жилийн эцэст: 800	Аймгийн хэмжээнд улаанбуудайн үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж, төмсний үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Улаан буудайн үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2 аж ахуйн нэгжийн 1733 га талбайд 7 төрлийн сортын үрийн хянан баталгааг хийж гүйцэтгэсэн. Улсын үрийн нөөц: Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК-д үрийн буудай 4828 тн, өөрийн үрийн нөөцөд 730 тн нийт 5558 тн стандартын шаардлага хангасан үрийн буудай үйлдвэрлэсэн.	100%
3.1.5	Арга хэмжээ 5. Хүлэмжийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх /ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	УТ 492.5 ЖДҮХС 100.0	Хамгаалагдсан хөрсний ургацын хэмжээ /тн/	304	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 300	Баян-Өндөр хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах 1.5 га газрыг олгон, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хашаажуулж, цахилгаан болон усны эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Шинэ хөдөө-Орхон төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 120 м.кв	100%

						талбай бүхий 26 ширхэг, нийт 3120 м.кв хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгж өвлийн хүлэмжийн төсөл хэрэгжүүлэхээр хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 140 м.кв өвлийн хүлэмж барих боломжтой болсон. Баян-Өндөр сумын 2 иргэн нийт 1129 м.кв өвлийн хүлэмж шинээр ашиглалтад оруулсныг дэмжин цахилгааны хөнгөлөлтөд хамрагдах 2024 онд шинээр нэмэгдсэн хүлэмжийн аж ахуйн судалгаанд хамруулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Хүлэмжийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шинэ хөдөө-Орхон төслийн хүрээнд 6*10 м харьцаатай 100 ширхэг хүлэмжийг өрхийн тариаланчдад олгосон. Аймгийн хэмжээнд нийт 273 иргэн, 4 аж ахуйн нэгж 30.3 мянган.м.кв хүлэмжийн талбайд тариалалт эрхлэж 332 тн ургац хураан авсан.	
3.1.6	Арга хэмжээ 6. Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарт тавих хяналтыг сайжруулах / ЗДҮАХ-ийн 7.3.2, ОАХТЖҮЧ 8.5.2, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	-	Тариалангийн газарт хөрсний төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн талбайн хэмжээ /га/	82.5	Эхний хагас жилд: 500 Жилийн эцэст: 1500	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын хянан баталгааг 13 иргэн, 4 аж ахуйн нэгжийн эзэмшлийн 59 нэгж талбарын 3125 га талбайд гүйцэтгэж зөвлөмж, арга зүйгээр хангасаж ажилласан. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолд туссан “Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ажлын хүрээнд хөрсний үржил шимийг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн иргэн, хуулийн этгээдэд татаас олгож байгааг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 4 аж ахуйн нэгж, 5	100%

						иргэн тус хөнгөлөлтөд хамрагдахаар Газар тариалангийн нэгдсэн системд хүсэлтээ илгээж, хөнгөлөлтөд хамрагдсан байна.	
3.1.7	Арга хэмжээ 7. Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	УТ 624.0 Жаргалант 650.0	Тариалангийн талбайг элэгдэл, эвдэрлээс хамгаалах зорилгоор нийт эргэлтийн талбайн 5 хувиас багагүйд ойн зурвас байгуулах	-	Нийт эргэлтийн талбайн 5 хувиас багагүйд ойн зурвас байгуулах	Тариалангийн талбайг элэгдэл эвдрэлээс хамгаалах ажлын хүрээнд Жаргалант сумын Бөөн бургас, 36-р тоцикт төмс, хүнсний ногооны талбайн 18.6 км хашааг шинээр барьж ашиглалтад оруулан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тариалангийн талбайн хашааны төмөр бетон шон 24000 ширхэгийг манай аймагт хуваарилсныг татан авч үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 9 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр эзэмшүүлсэн. Үүний үр дүнд нийт 9 аж ахуйн нэгж 254 иргэний эзэмшлийн 5153 га талбайг хашиж хамгаалсан. Тус арга хэмжээнд улсын төсвөөс 2024 онд 624.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2024 онд 650.0 сая төгрөг зарцуулсан. Тариалангийн талбайг хашаажуулснаар цаашид ойн зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Хантөгөл хайлаас ХХК, Алтан үрслэг ХХК нь 10 га төмс, хүнсний ногооны талбайг хамгаалж 300 метр урттай ойн зурвас байгуулсан. Тариалангийн талбайн нийт эргэлтийн талбайн 5.8 хувьд ойн зурвас байгуулсан.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Хүнсний үйлдвэрлэл, хангамж, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох болон экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх, чиг үүрэг хэрэгжүүлнэ.							
4.2.	Зорилт 1. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.	УТ 900.0 ОНТ	ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3, ЗДҮАХ-ийн 4.2, Орхон	Махны 60.2, сүүний 4.0, цагаан идээний 4.6,	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчд	Хүнс, хөдөө аж ахуйн хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялуун	100%

		520.9 Баян-Өндөр 100.0 Жаргалант 20.0	аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, ХХААХҮС, Засаг даргын 2023 оны хамтран ажиллах гэрээ	гурилан бүтээгдэхүүний 42.6, улаан буудай 100.0, төмсний 43.3, хүнсний ногоо 100.0 хувь тус тус орон нутгийн үйлдвэрлэл ээр хангаж байна.	ийг төсөл, хөтөлбөрт хамрагдахад арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин хамруулах, орон нутгийн хүнсний брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ	бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдэж, брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой болсон. Аймгийн хэмжээнд хиам 4.9, нарийн боов 5.9, хэвийн боов 89.9, талх 52.9 хувиар үйлдвэрлэл өсч, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 73.6 хувь, сүүний 8.3 хувь, цагаан идээний 7.1 хувь, гурилын 3.6 хувь, гурилан бүтээгдэхүүний 59.2 хувь, төмсний 51.6 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна.	
4.2.1	Арга хэмжээ 1. Нөөцийн мах худалдаанд гарах бэлтгэл ажлыг зохион байгуулах, борлуулалтад хяналт тавьж ажиллах /ЗДҮАХ-ийн 4.2, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ОНТ 500.0 Баян-Өндөр 100.0 Жаргалант 20.0	Бүрдүүлсэн махны хэмжээ, улирлын хэрэгцээг хангах хувь	-	Эхний хагас жилд: Хаврын улирлын махны хэрэгцээний 20 хүртэл хувийг хангах 200 тн махны нөөц бүрдүүлэх	Аймгийн хүн амын 2024 оны хаврын махны хэрэгцээний 21.6 хувь буюу 200 тн махыг Эрдмийт ХХК, Жаргалант мах импекс ХХК-иуд бэлтгэн нийлүүлсэн. 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд Баян-Өндөр сумын 17 багийн 29 цэг, Жаргалант суманд 2 нийт 31 цэгээр ангилан савласан ястай үхрийн мах 1 кг нь 9000, хонины мах 1 кг нь 6400, ямааны мах 1 кг нь 4900 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд худалдаалж, хаврын улиралд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэн ажилласан. Үр дүнд хэрэглэгчдэд үхрийн мах 7800, хонины мах 8300, ямааны мах 5500 төгрөгийн хямд үнэтэй хүргэсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/681 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нөөцийн махны бэлтгэл, хадгалалт, ангилан савлалт, борлуулалт, хүртээмжийн байдалд	100%

						аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хэвлэл мэдээллийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, сумдын Засаг даргын тамгын газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хамтран нэгдсэн хяналтыг 5, хяналт хийх байгууллагууд 21, нийт 25 удаагийн хяналтыг хийж, махны нийлүүлэлт удаашралтай байгаа талаарх мах худалдан борлуулж буй дэлгүүрүүдээс ирүүлсэн 12 саналыг шийдвэрлүүлэн ажилласан.	
4.2.2	Арга хэмжээ 2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин ажиллах, бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх /ЗДҮАХ-ийн 4.2, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	-	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэгчийн тоо, нэмэгдсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ	Аймгийн хүн амын хэрэгцээт малын махны 60.2, сүүний 4.0, цагаан идээний 4.6, гурилан бүтээгдэхүүний 42.6, улаан буудай 100.0, төмсний 43.3, хүнсний ногоо 100.0 хувь тус тус орон нутгийн үйлдвэрлэл ээр хангаж байна.	Эхний хагас жилд: Үйлдвэрлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамруулах, брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх Жилийн эцэст: Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамрагдахад арга зүйн зөвлөгөө өгч, орон нутгийн хүнсний брэнд	Хүнс, хөдөө аж ахуйн хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялууны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдэж, 10 сарын байдлаар 26 үйлдвэр статистик мэдээнд хамрагдаж, 27.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 28.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалтыг хийж, 2275 тн мах, махан бүтээгдэхүүн, сүү 343.9 мян.л, тараг 23 мян.л, зайрмаг 468.0 мян.ш, гурил 93.1 тн, гурилан бүтээгдэхүүн 2743.3 тн, савласан цэвэр ус 2572.3 мян.л, жүүс 11.1 мян.литр буюу 8 нэрийн 21 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн 346.4 тн хонины махыг Иран улсад экспортлож, хонины мах 46.4, хиам 4.9, нарийн боов 5.9, хэвийн боов 89.9, талх 52.9, савласан цэвэр ус 52 хувиар, сүү 2.0, зайрмаг 2.1, жүүс 4.6 дахин үйлдвэрлэл өссөн.	100%

					бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ		
4.2.3	Арга хэмжээ 3. Орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах / ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3, ЗДҮАХ 4.2, 4.3, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.5.5/	ОНТ 20.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Аймгийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-1, Төв, Хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-1, захирамжийн сургалт-1, гэрээгээр хийсэн сургалт-1 буюу нийт 2 удаагийн уралдаан, 2 удаагийн сургалт	Эхний хагас жилд: 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулна. Жилийн эцэст: 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулна	Орхон аймгийн Тогоочдын холбоотой хамтран 1 удаагийн 2 арга хэмжээ, 1 удаагийн мэргэшүүлэх сургалт нийт 3 арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Тогооч нарын холбоо, Орхон аймгийн Тогоочдын холбоо, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран Монгол үндэсний хоол, идээ ундааны “Улсын аварга тогооч” шалгаруулах анхдугаар уралдааныг 7 төрөлд, Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажиллагсдын спортын анхдугаар наадмыг 5 төрөлд явуулж, 18 аймаг, 7 дүүргийн нийт 700 гаруй салбарын ажиллагсад оролцож, 58 шагналт байрыг эзлүүлэн шагнаж урамшуулсан. Үр дүнд орон нутаг анх удаа тогооч нарын улсын зэрэглэлтэй арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 426 тогоочийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн харилцан туршлага судлуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт, үнэлгээ судалгааны институтын “Мэргэжлийн түвшин тогтоох чадамжийн ARP” үнэлгээ олгох 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, нийт 35 тогоочийг хамруулсан.	100%
4.2.4	Арга хэмжээ 4. Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах	-	Зохион байгуулсан сургалтын тоо	2 удаагийн сургалт зохион байгуулсан	Эхний хагас жилд: 1 удаагийн сургалт	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 4 хяналтын чиглэлээр сургалт зохион	100%

	сургалтуудыг үе шаттай зохион байгуулах / ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3, ЗДҮАХ 4.2, 4.3, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.5.5/				зохион байгуулна. Жилийн эцэст: 1 удаагийн сургалт зохион байгуулна.	байгуулсан. Сургалтыг Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй Best хөтөлбөр, Ногоон шийдэл хөтөлбөр, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран нийт 7 удаагийн сургалтад хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл, газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч 481 аж ахуйн нэгж, иргэний төлөөллийг хамруулсан. Үр дүн: Сургалт зохион байгуулснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч, үйлдвэрлэгчдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, бүртгэл хөтлөлт, хууль, журам, стандартын хэрэгжилт өмнөх оноос 5%-иар нэмэгдэж 86.5%-д хүрсэн.	
4.2.5	Арга хэмжээ 5. Хүнсний хангамж, аюулгүй байдлын чиглэлийн мэдээлэл, нэвтрүүлгийг тогтмол явуулж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг нийтэд таниулан суртацилах / ЗГҮАХХАХТ-ийн 3.3.3, ЗДҮАХ 4.2, 4.3, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.5.1/	ОНТ 0.9	Бэлтгэн нийтэлсэн нэвтрүүлэг, шторк, контентын тоо	“Хүнсний аюулгүй байдлын цаг” тусгай хөтөлбөрт 25 удаагийн мэдээлэл, 2 удаагийн нэвтрүүлэг, Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 9 постер, 4 бичлэг, 5 төрлийн гарын авлага гаргаж нийтэд хүргэсэн.	Эхний хагас жилд: Нэвтрүүлгийг тогтмол явуулж хэвшинэ. Жилийн эцэст: Нэвтрүүлгийг тогтмол явуулж хэвшин, үр дүнг тайлагнана	Нөөцийн махны чанар, эрүүл ахуйн тухай ойлголт, бэлтгэл, хадгалалтын горим, нөхцөл, тээвэрлэлт, худалдан борлуулах цэгийн байршил, үнийн талаарх мэдээлэл, явцын тухай нийт 2 удаагийн нэвтрүүлэг, 1 постер, 1 шторкийг бэлтгэн байгууллагын фэйж хуудас, аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Үр дүнд хэрэглэгчид нөөцийн махны үнэ, байршил, махны чанарын талаарх нэгдсэн ойлголтыг авч, нөөцийн махтай холбоотой санал, шүүмжлэл өмнөх оны мөн үеэс 90 хувиар буурч, хэрэглээнд нөлөөлсөн.	100%

Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.1	Зорилт 1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжин, хөгжүүлнэ	УТ 1,100.0 ОНТ 10.0 ЖДҮДС 1,271.5 ХХСан 250.0 Шинэ хоршоо 5,597.2 БДС 3,918.1	Дэмжлэг авсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо	6 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 192.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжин ажилласан байна.	Сайхан шинэлээрэй”, Амар байна уу?, “Монгол сар, Монгол бэлэг” “Цагаан сар-2024” зэрэг 5 үзэсгэлэн худалдаанд 110 аж ахуйн нэгж оролцсонж, давхардсан тоогоор 500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдсан. Нүүдэлчин 2024” дэлхийн соёлын фестиваль үндэсний дээл хувцас арьсан эдлэл, хивс, хивсэн бүтээгдэхүүн, гоёл чимэглэл, давсан урлал, мөн нүүдлийн цайны соёлыг сурталчилан 10 гаруй жижиг дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж 60.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Намрын ногоон өдрүүд үндэсний үйлдвэрлэл-2024 өргөтгөсөн үзэсгэлэн худалдаанд хүнс, хөнгөн, газар тариалангийн чиглэлийн 12 иргэн, аж ахуйн нэгж оролцож 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Хойд бүсийн түншлэл-2024” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 150 өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэгч оролцон 69.2 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. “Өвлийн идэш-2024” мал аж ахуйн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний өргөтгөсөн худалдааг зохион байгуулж малчид, хоршоодыг дэмжин ажилласан.	100%
5.1.1	Арга хэмжээ 1. Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах / ЗДҮАХ-ийн 7.2.3,	ОНТ 10.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан	Эхний хагас жилд: 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.	Аймгийн хэмжээнд брэнд бүтээгдэхүүний сургалтанд хамрагдсан 20 аж ахуйн нэгжээс 8 аж ахуйн нэгжийг сонголтоор авч брэндийн чиглэлээр мэргэшсэн багш урьж сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Үүний үр дүнд шүхрэн брэндийг хэрхэн бий болгох, бэлгийн багц гаргах 5 аж ахуйн нэгжийг шалгаруулж	100%

	ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/					сав баглаа боодлын дэмжлэг үзүүлэн 10.0 сая төгрөг олгосон. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль-2024” арга хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг, гадаадын 12 улсаас 1000 орчим өвлөн уламжлагчид үзэсгэлэн худалдаанд оролцож, соёлын салбарын 150 гаруй байгууллагын нийт 6000 гаруй хүн оролцсон арга хэмжээнд Орхон аймгийн 10 брэнд /Өндөрлөг брэнд, Сампин брэнд, Угалз брэнд, Жигүүр брэнд, цайны брэнд/ үйлдвэрлэгч иргэн аж ахуйн нэгж 80 гаруй нэр төрлийн импорт орлох бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцож 60.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	
5.1.2	Арга хэмжээ 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжих / ЗГҮАХХАХТ-ийн 3.3.12, ЗДҮАХ-ийн 7.2.4/	УТ 1,100.0 ЖДҮДС 1,271.5 ХХСан 250.0 Шинэ хоршоо 5,597.2 БДС 3,918.1	Дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо, мөнгөн дүн	32 иргэн аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөг	Эхний хагас жилд: зээлийн бодлогоор дэмжсэн байна. Жилийн эцэст: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжсэн байна.	2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 3 аж ахуйн нэгж 1100.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 40 хоршоо 5,597.2 сая төгрөг, нийт 54 аж ахуйн нэгжид 8,218.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 55 шинэ ажлын байр нэмэгдсэн. Мөн 40 хоршооны гишүүн 150 малчин өрх 3.9 тэрбум төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан.	100%
5.1.3	Арга хэмжээ 3. Оёдлын үйлдвэр, эрхлэгчдийг чадавхижуулах сургалт арга хэмжээ зохион	-	Арга хэмжээний тоо	1 удаагийн сургалт зохион байгуулсан	Эхний хагас жилд: 1 удаагийн сургалт зохион байгуулсан	Оёдлын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр Хөгжлийн шийдэл ТББ-ын BEST хөтөлбөртэй хамтран 11 удаагийн сургалт, арга хэмжээг онол практик хосолсон байдлаар зохион байгуулж амжилттай оролцсон аж ахуйн нэгжүүдэд чадамжийн СЕРТИФИКАТ гардууллаа. Сургалтанд 25 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Сургалт, арга хэмжээний үр	100%

	байгуулах / ЗГҮАХ-ийн 3.3.12, ЗДҮАХ-ийн 7.2.3/					дүнд идэвхигүй байсан мэргэжлийн холбоогоо идэвхжүүлж удирдах зөвлөлөө шинэчлэн гишүүнчлэлээ нэмэгдүүлснээр салбарын үйл ажиллагаа идэвхжсэн.	
5.1.4	Арга хэмжээ 4. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт арга хэмжээ зохион байгуулах / ЗГҮАХ-ийн 3.3.12, ЗДҮАХ-ийн 7.2.3/	-	Арга хэмжээний тоо	-	Эхний хагас жилд: 1 удаагийн сургалт зохион байгуулсан байна	Барилгын салбарын үйлдвэрлэгчдийг чадавхижуулах “LEVEL UP” дэд хөтөлбөрийг эхлүүлж, хөтөлбөрийн хүрээнд “Компанийн засаглал ба хөрөнгө оруулалт” “Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь” Бизнес төсөл хэрхэн боловсруулах вэ?, Барилгын салбарын хөгжлийн чиг хандлага, “Худалдан авалт ба нийлүүлэлтийн боломжууд” сэдвээр нийт 10 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулсан. Сургалтад 35 аж ахуйн нэгжийн төлөөлөл тогтмол оролцож олон талын мэдлэг мэдээлэл олж авсан. Сургалтад амжилттай оролцсон аж ахуйн нэгжүүдэд чадамжийн СЕРТИФИКАТ гардууллаа. Хөтөлбөрийн хүрээнд барилгын үйлдвэрлэл эрхлэгчдийн мэргэжлийн холбоо байгуулагдан ажиллаж байна	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, ахуйн үйлчилгээний салбарын санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг хүлээнэ.							
6.1	Зорилт 1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын бодлогын хэрэгжилтийг хангах	ЖДҮХС 1,271.5	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3 удаа	3 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.	ЖДҮХС-аас хөнгөн, хүнс, газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн 8 аж ахуйн нэгжид 1,271.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. Үүний үр дүнд 16 ажлын байр шинээр нэмэгдэж 25 ажлын байр хадгалагдсан байна. Оёдлын үйлдвэр эрхлэгч, барилгын материал үйлдвэрлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр 2 тусгай хөтөлбөр боловсруулан, 10 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж 60 иргэн аж ахуйн нэгжийг хамруулсан.	100%
6.1.1	Арга хэмжээ 1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг	-	Өдөрлөг, үзэсгэлэн худалдаанд оролцуулсан	Зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд	Эхний хагас жилд: Зохион байгуулагдсан үзэсгэлэн	Сайхан шинэлээрэй”, Амар байна уу?, “Монгол сар, Монгол бэлэг” “Цагаан сар-2024” зэрэг 5 үзэсгэлэн худалдаанд 110 аж ахуйн нэгж оролцсонж, давхардсан тоогоор 500	100%

	сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор өдөрлөг, үзэсгэлэн худалдаанд бизнес эрхлэгчдийг оролцуулах / ЗДҮАХ-ийн 7.2.3, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ /		бизнес эрхлэгчдийн тоо	250 иргэн аж ахуйн нэгжийг оролцуулсан	худалдаанд 100 бизнес эрхлэгчийг оролцуулсан байна. Жилийн эцэст: Зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд 150 бизнес эрхлэгчийг оролцуулсан байна.	гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдсан. Нүүдэлчин 2024” дэлхийн соёлын фестиваль үндэсний дээл хувцас арьсан эдлэл, хивс, хивсэн бүтээгдэхүүн, гоёл чимэглэл, давсан урлал, мөн нүүдлийн цайны соёлыг сурталчилан 10 гаруй жижиг дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж 60.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Намрын ногоон өдрүүд үндэсний үйлдвэрлэл-2024 өргөтгөсөн үзэсгэлэн худалдаанд хүнс, хөнгөн, газар тариалангийн чиглэлийн 12 иргэн, аж ахуйн нэгж оролцож 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Хойд бүсийн түншлэл-2024” орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 150 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцсон.	
6.1.2	Арга хэмжээ 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах / ЗДҮАХ-ийн 7.2.2, Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 4.4.3/	-	Сургалт арга хэмжээний тоо	2 удаагийн сургалт зохион байгуулсан	Эхний хагас жилд: 2 удаагийн сургалт зохион байгуулна.	“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын танилцуулга, зээл олгох, төсөл бичих, хавсралт материалын иж бүрдэл, анхаарах асуудлаар 5 удаагийн шаталсан сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 88 жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулан 4 төрлийн гарын авлага материалаар ханган ажилласан. Мөн оёдлын үйлдвэрлэл эрхлэгчид, барилгын салбарын үйлдвэрлэгчдийг чадавхижуулах чиглэлээр 30 хоногийн хугацаатай 11 удаагийн цогц сургалтыг зохион байгуулж амжилттай	100%

						суралцсан аж ахуйн нэгжийн төлөөлөлд чадамжийн гэрчилгээ олгосон.	
6.1.3	Арга хэмжээ 3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах. /ЗГҮАХХАХТ-ийн 3.3.13, ЗДҮАХ-ийн 7.2.1, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт/	УТ 1,100.0 ЖДҮДС 1,271.5 ХХСан 250.0 Шинэ хоршоо 5,597.2	Зээлд хамрагдалт /төсөл, мөнгөн дүн/	32 иргэн аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөг	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.	2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 3 аж ахуйн нэгж 1100.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 40 хоршоо 5,597.2 сая төгрөг, нийт 54 аж ахуйн нэгжид 8,218.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 55 шинэ ажлын байр нэмэгдсэн.	100%
6.1.4	Арга хэмжээ 4. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих сангаас зээл авсан зээлдэгчдийн төсөл хэрэгжилтийн үр дүнд хяналт-үнэлгээ хийх, сурталчилах / ЗГҮАХХАХТ-ийн 3.3.13, ЗДҮАХ-ийн 7.2.1, ЗГХЭГ-ын ХЭГ/444-ийн 8 дахь заалт/	-	Хяналт, сурталчилгааны /тоо/	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан	Жилийн эцэст: 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан нийт зээлдэгчдээс түүвэр судалгаагаар сонгогдсон 25 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Хяналт хийж ажилласаны үр дүнд анхаарал хандуулах ангилалд байгаа 12 зээлдэгчийн 18.3 сая төгрөг бүрэн төлөгдсөн. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Орхон аймагт олгосон зээлдэгчийн үйл ажиллагаа, төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу ашигласан байдал, хуримтлагдсан зээлийн зөрчлийг бууруулах, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, зэрэгт хяналт-мониторинг хийсэн. Энэхүү ажлын хүрээнд аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн удирдамжийн дагуу ажлын хэсэг гарч Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Улаанбаатар хот Налайх дүүрэг, Булган аймгийн Бугат, Хангал, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын нутагт хэрэгжиж байгаа хүнс, хөнгөн, газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн 20 аж ахуйн нэгжийн төслийн үйл ажиллагаатай танилцсан. Эдгээр ААН-үүдэд	100%

						тус сангаас 2.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Хяналтаар хэрэгжээгүй нэг зээлийн эргэн төлөлтийг бүрэн хийлгэж хаалгасан. Анхаарал хандуулах ангилалд байгаа 1 зээлдэгчээс 21.0 сая төгрөгийн төлөлт хийлгэж ангилал ахиулсан үр дүнтэй ажиллаа.	
6.2	Зорилт 2. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /ЗДҮАХ-ийн 7.2.2/	ОНТ 20.0	1.Мэдээллийн сангийн баяжилт /нэр төрөл/ 2.Чадавхижуулах сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	1.Мэдээллийн сангийн баяжилт /нэр төрөл/ 2.Чадавхжуулах сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн санд баяжилт хийж, чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.	Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 365 цэгт аж ахуй нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 14 буюу 4.0 хувь нь нийтийн халуун ус, 85 буюу 23.2 хувь нь үсчин, гоо сайхан, 94 буюу 25.7 хувь нь хувцас захиалга, засвар, 4 буюу 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 3 буюу 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 3 буюу 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 24 буюу 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 19 буюу 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 8 буюу 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 125 буюу 34.2 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн холбоодтой хамтран ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 190 хүнийг хамруулсан	100%
6.2.1	Арга хэмжээ 1. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах. /ЗДҮАХ-ийн 7.2.2, Ахуйн үйлчилгээний салбарыг	ОНТ 20.0	Сургалтанд хамрагдсан хүний тоо	3 сургалт зохион байгуулж, 212 иргэн хамрагдсан.	Эхний хагас жилд: 3 удаагийн сургалт зохион байгуулсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн холбоодтой хамтран ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 190 хүнийг хамруулсан. Үүнд:	100%

	хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 4.4.3/					1. “ДЭЛХИЙН” хэмжээний артист бэлтгэн гаргах, өөртөө ажлын байр бий болгох, хувь хүний ур чадварыг хөгжүүлэх зорилгоор Гоёлын шивээсний техникийн сургалтыг явуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификатыг 10 хүнд олгосон. 2.Үс тайралтын төрөл, Үс будалтын төрөл, Үндсэн будгийн ерөнхий онол болон техникийг зааж модель дээр хийж үзүүлэх сургалтад 50 гаруй үсчид хамрагдсан. 3.Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан "Хайр нэмье" эмэгтэйчүүдийн өдөрлөгт 100 эмэгтэйг хамруулсан. 4.“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд “Гепатитын вирусийн халдварын тандалт, урьдчилан сэргийлэлт” бэхжүүлэх нь” сэдэвт чадавхжуулах сургалтыг Орхон аймгийн үсчин, гоо сайханч, хумс засалч, гоёлын шивээсний үйлчилгээ эрхлэгч 30 хүнийг хамруулсан.	
6.2.2	Арга хэмжээ 2. Явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах. /Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 4.2.5/	-	1.Хамрагдсан хүний тоо 2.Борлуулалтын орлого	5 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 130 иргэн хамрагдаж, 1.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.	Эхний хагас жилд: 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.	Жаргалант сумын иргэдэд ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүрч үйлчлэх, иргэдийн зардлыг хэмнэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын ахуйн үйлчилгээг” 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Жаргалант сумын Соёлын төвд зохион байгуулж, 185 иргэнд 14 чиглэлийн үйлчилгээг үзүүлэн 1.8 сая төгрөгийн орлоготой ажилласан.	100%
6.3	Зорилт 3. “Хоршоодыг хөгжүүлэх нийгмийн хэмжээний	ОНТ 25.5 Шинэ хоршоо	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөни	2023 оны үйл ажиллагаан ы	Загвар хоршоо байгуулагдах нөхцөл	“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	100%

	хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлнэ. /МУХТЖҮЧ 3.3.5, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	5,597.2 XXСан 250.0 БДСан 3,918.1	й биелэлтийн хувь	төлөвлөгөөнд хоршоог хөгжүүлэх чиглэлээр 6 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан	бүрдсэн байна.	тухай” А/194 дүгээр захирамжаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 11 арга хэмжээ зохион байгуулж хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Монгол Улсын Засгийн газраас санаачилсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд мал аж ахуйн чиглэлийн 39 хоршоо шинээр байгуулагдаж, 40 хоршооны гишүүн малчид 5,597.2 сая тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдаж тоног төхөөрөмж, үржлийн мал худалдан авч малын сүргийн бүтцийг сайжруулах, малын тэжээл тариалах зориулалтаар зээл авсан байна. Мөн 40 хоршооны гишүүн 150 малчин өрх 3.9 тэрбум төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан. Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд Баян-Өндөр сумын мал аж ахуйн чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо 100.0 сая, Лууснын дагина хоршоо 50.0 сая, Жаргалант сумын БЛГЯ хоршоонд 100.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан ажлын байрны өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэн 28 ажлын байр хадгалагдаж, 5 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.	
6.3.1	Арга хэмжээ 1. “Хоршоодыг хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлнэ. / МУХТЖҮЧ 3.3.5, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ОНТ 20.0	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	Хоршоог хөгжүүлэх чиглэлээр 6 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилт 100 хувь	Жилийн эцэст: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангасан байна	“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” А/194 дүгээр захирамжаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт 11 арга хэмжээг тусган хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд: 1.Хоршоодыг чадавхжуулах 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 170 хүнийг хамруулсан.	100%

						2.Туршлага судлах аялалд нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй оролцож Булган, Хөвсгөл аймгийн 12 үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан. 3.Хоршоологчдын улсын зөвлөгөөнд 15 хоршооны төлөөлөл амжилттай оролцож спортын бага наадамд ширээний теннисийн төрөлд 2-р байр эзэлсэн. 4."Шинэ хөдөө- үйлдвэрлэгч өрх" төслийн хүрээнд сүү савлагч тоног төхөөрөмжийг мал аж ахуйн чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо, Хушт булуу хоршоонд гэрээгээр эзэмшүүлж дэмжлэг үзүүлсэн. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд: 1.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлтийн үйл ажиллагаанд Орхон аймгийн 72 төлөөлөгч оролцсон. Тус үйл ажиллагаа Улаанбаатар хот Дунд гол дахь UJ Arena төвд зохион байгуулагдсан бөгөөд 21 аймгийн 300 сумын 3100 гаруй төлөөлөгч оролцож “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний зорилго, хоршоонд нэгдэхийн ач холбогдол, хоршоо байгуулах, бүртгүүлэх, хэрхэн элсэх талаар зөвлөмж, хоршооны сайн туршлагуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. 2.Хойд бүсийн нээлтийн арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 06-нд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Спорт цогцолборт зохион байгуулж Орхон, Хөвсгөл, Булган аймгийн нийт 1402 малчин оролцсон.	
6.3.2	Арга хэмжээ 2. Хоршоодын туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах /3.5.4, ХХААХҮС, Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	ОНТ 5.5	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан	Эхний хагас жилд: 1 удаагийн арга хэмжээ зохион	Аймгийн Засаг даргын 2024 оны А/194 дүгээр захирамжийн хүрээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, брэнд бий болгох зорилгоор үйлдвэрлэгчдийг Булган, Хөвсгөл аймгуудын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл	100%

					байгуулсан байна.	ажиллагаатай танилцуулан харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Туршлага судлах аялал 30 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдаж, Булган, Хөвсгөл аймгийн 12 жижиг, дунд үйлдвэр, хоршооны үйл ажиллагаатай танилцсан.	
Стратегийн зорилго 7. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна.							
7.1.	Зорилт 1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна. /Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээ/	УТ 8.63	1.Шалгалт хийсэн объектын тоо 2. Үр дүн (тайлагналт)	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулсан	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулж ажиллана	2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт шалгалт-56, төлөвлөгөөт бус -251 урьдчилан сэргийлэх шалгалт 811 нийт 1118 объектод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар нийт 2905 зөрчлийг илрүүлснээс газар дээр нь мэргэжил арга зүй, зөвлөмж, зөвлөгөө өгч 2004 зөрчил буюу 69%-ийг арилгуулсан. Зөрчил арилгуулалтын 5%-иар буурсан.	100%
7.1.1	Арга хэмжээ 1. Их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх / Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 6.2./	УТ 0.65	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо	102 объект	Эхний хагас жилд: 1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт-10 2.Хүнсний худалдааны хяналт-10 3.Хүнсний үйлдвэрлэлийн хяналт-10 4.Ургамал хамгаалалын хяналт -8 Жилийн эцэст: 1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт-5 2.Хүнсний худалдааны хяналт-5 3.Хүнсний	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 4 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийт 56 объектод хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар: -Хууль сахин мөрдөлтийн түвшин 78.3% - Эрсдэл үүсэх магадлал 21.7% Их эрсдэлтэй объект-3 Дунд эрсдэлтэй объект-10 Бага эрсдэлтэй объект-43 / 100% / - Зөрчлийн тоо 516 Хүрсэн түвшин: 1. 2023 оны мөн үетэй харьцуулахад төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүрэн хийж гүйцэтгэсэн байна. 2. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15 объектод илэрсэн зөрчлийг арилгуулахаар 215 заалт бүхий 15 албан шаардлага хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 187 заалт биелж, эрсдэл үүсэх магадлал 20.2%-аар буурч, хууль сахин мөрдөлт 86.5%-болж өссөн байна.	100%

					үйлдвэрлэлийн хяналт-5 4.Ургамал хамгаалалын хяналт -3		
7.1.2	Арга хэмжээ 2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдлын, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, эрсдэлийг бууруулах / Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.3.1/	УТ 0.48	1.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 2.Зөрчил арилгалтын хувь	Өргөдөл, гомдол, хүсэлт-195	Өргөдөл, гомдол, хүсэлтийг хууль журмын дагуу 100% шийдвэрлэж, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ	Тайлант хугацаанд 279 албан бичиг, 100 өргөдөл, хүсэлт, гомдол ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт ирүүлсэн 195 аж ахуйн нэгж, газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2 аж ахуйн нэгж, шинээр хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй 54 нийт 251 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 1255 зөрчлийг илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь 889 зөрчил буюу 70.8 хувийг арилгуулж, 195 аж ахуйн нэгжид ажлын байрны дүгнэлтийг үйлдэж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2 аж ахуйн нэгжид 18 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Биелэлт 89%-тай дүгнэгдсэн.	100%
7.1.3	Арга хэмжээ 3. Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар урьдчилан сэргийлэх шалгалт хийх. /Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жил, Хичээлийн шинэ жил/ /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.3.1/	УТ 0.45	Зөрчил арилгуулалтын хувь	315 объектод	Эхний хагас жилд: 100 Жилийн эцэст: 240	Салбарын хяналтын газрын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 9 удирдамжийн хүрээнд 4 хяналтын чиглэлээр нийт 811 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтын үр дүнд: 1. Шалгалтын явцад 1650 зөрчлийг илрүүлж, 1115 буюу 67.6%-ийг газар дээр нь арилгуулсан. 2. Давхардсан тоогоор хүнсний чиглэлийн 297 аж ахуйн нэгж, 627 иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 3. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2 аж ахуйн нэгжид 18 заалт бүхий албан шаардлага, 658 заалт бүхий 80 зөвлөмж үйлдэж, биелэлтийг хангуулж ажилласан. 4. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 296 зөрчлийг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилт 86.5 хувьд хүрсэн.	100%

						5. Арилаагүй үлдсэн 239 зөрчлийн шалтгаан нь дэд бүтэц болон тухайн ажлын байрны зохион байгуулалт, стандарт шаардлага хангахгүй байгаа зэрэг шалтгаан байна.	
7.1.4 .	Арга хэмжээ 4. Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх / Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.4.1/	УТ 0.45	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагын биелэлтийг шалгах	9 объект	Жилийн эцэст: Эрсдэлийн түвшинг бууруулна	Төлөвлөгөөт хяналт шалгалтаар хоол үйлдвэрлэл, хүнс, худалдаа, хүнсний үйлдвэрлэл, ургамал хамгааллын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15, төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 2, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 2 буюу нийт 19 объектод 233 заалт бүхий албан шаардлага хүргүүлснээс 203 заалт биелсэн байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтын үр дүнд: Эрсдэл үүсэх магадлал 14.9% болон буурч, хууль сахин мөрдөлт 84.1% болж өссөн байна	100%
7.1.5 .	Арга хэмжээ 5. Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийж, дүгнэлт гаргах / Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5/	УТ 0.02	Шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо нэмэгдэх	2 объект	Хүсэлт ирсэн тухай бүрт	Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэлтэй 1 аж ахуйн нэгж, 2 цехээс ирүүлсэн албан бичгийн дагуу Эрүүл мэнд яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын даргын хамтран баталсан 10-00/14 дугаартай удирдамжаар 8.29.1 кодтой “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх” хяналтын хуудсаар төлөвлөгөөт бус шалгалт хийхэд тус 3 үйлдвэрийн ажлын байр нь “бага” эрсдэлтэй үнэлэгдсэн тул ажлын байрны дүгнэлт олгов.	100%
7.1.6 .	Арга хэмжээ 6. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд чиглэсэн сургалт хийх. /ЗГҮАХ, ЗДҮАХ, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль/	УТ 6.08	Сургалтад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж зохион байгуулсан байна.	3 удаа	Эхний хагас жилд: Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд 1 удаагийн сургалт зохион байгуулна	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 4 хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтыг Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй Best хөтөлбөр, Ногоон шийдэл хөтөлбөр, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран нийт 9 удаагийн сургалтад хүнсний худалдаа, үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, газар тариалангийн үйл	100%

ХАВСРАЛТ №1. БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ТӨСӨВ

№	Зардлын зүйл анги	Төлөвлөгөө /мян/төг/
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	625,640.0
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,200.0
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,960.0
4	Хангамж, бараа материалын зардал	12,370.0
5	Нормативт зардал	1,800.0
6	Эд хогшил, урсгал засварын зардал	39,360.0
7	Томилолт, зочны зардал	17,200.0
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	84,310.0
9	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	109,750.0
10	Бараа, үйлчилгээний бусад зардал	2,590.0
Нийт төсвийн дүн		1,042,180.0

